



БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ

Соёлын төв өргөө, Амарын гудамж 2,  
Бага тойрог-1, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: 7011-2010

2021.01.05 № 01.  
танай 2020.12.24 -ны № 10/7190 -т

Г НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт болон Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.



ДАРГА

Г. ГАЛДӨЛ

3140860220

**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ-ОНӨТҮГ**  
**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН**  
**2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР

Улаанбаатар хот

№	ЗААЛТ	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР		НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨӨЛТ ӨРХ БҮРТ Ж.БАТБАЯСГАЛАН	ХҮБРЭЛҮҮЛСҮҮЛЭХ ГИШҮҮН
		ХҮБРЭЛҮҮЛСҮҮЛЭХ ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН	ХҮБРЭЛҮҮЛСҮҮЛЭХ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН		
1.	1.3.3	Мал аж ахуйт эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, СҮУ, БМТН-ОНӨТҮГ махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар НИЙСЛЭЛИЙН хүн амьн СҮУ, махны хэрэгцээг дотоодын бүтээдэхүүнээр хангана.			
		<b>Биелэлт. 2017 он:</b> Сүүний чиглэлийн үнээний загвар ферм барих тендерт шалгарсан “Сайн констракшн” компани барилгын ажлыг дуусган, улсын комисст хулээлтэн өгөхөд бэлэн болсон. НИЙСЛЭЛИЙН засаг даргын А-873 тоот захирамжийн дагуу хотын мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс гаргасан малнаас 30 туталтай үнээг сонгон авч, фермд байрлуулсан. Үнээнд зориулан 50 тонн байгальн хадлан бэлтгэж, 13 тонн хэвэг худалдан авч, нийлүүлсэн. <b>2018 он:</b> Бага оврын хөдөө аж, ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хурээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тендерийг 2 дугаар сард зарлаж, 3 дугаар сард нээсэн боловч нэг ч компани санал ирүүлээгүй тул тендерийг дахин зарласан. Тендерийн дахин сонгон шалгаруулалт 4 дүгээр сарын 16 нд болж, хоёр компани санал ирүүлснээс “Глобал бизнес” ХХК шалгарч, 2018 оны 5 дугаар сарын 25 ны өдөр Хүнс, хөдөө аж ахуйн газартай гэрээ байгуулсан.		75%	80%

Хөдөө аж ахуйн зориулалт бүхий анжис, хүнд диск, роторт сийрүүлэгч, тэмс ургэлж, төмс хураатч, усалгааны систем, нарийн ногооны ургэлж, хор цацагч төмсний кон болон 5 тоннын даацтай өргөгч кран зэрэг 10 төрлийн тоног төхөөрөмжүүдийг графикийн дагуу хугацаандаа нийлүүлэгдсэн. НХХААГ-ын даргын тушаалаар томилогдсон хүлээн авах комисс 2018 оны 10 дугаар сарын 02 –ны өдөр техник тоног төхөөрөмж бурийт нэг бурчлэн угсарч, ажиллуулан, хүлээн авсан. Төслийн хүрээнд 2017 онд нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийж, иргэн, аж ахуйн нэгжийн захиалын дагуу зориулалтын техник ашиглан нийт 10 га талбайд боловсруулалт хийж, 34 га талбайд өтөг бууч цацаж, 12 га талбайд овьёс хадаж, тармаж, пресспэх ажлыг гүйцэтгэсэн.	Малын өтөг, бууч 50 тонныг ойр хавийн фермерүүд болон өөрийн фермийн аж ахуйгаас цуглуулан, ёвс, хог ургамлын улдэгдэл, хаягdsan модны мөчир, ногооны хальс, хоол хүнсний улдэгдэл зэрэг зарим органик хог хаягдал зэрэгтэй хольж, норгох, холих ажлыг технологийн дагуу хийж органик бордоо бэлтгэсэн.	Хөрсний чанарыг сайжруулах зорилгоор азот, фосфор, калийн нийлийн эрдэс бордоогоор зориулаалтын бордоо цацагч машин ашиглан 20 га газрыг бордсон.	2019 онд. “Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж хадгалах байр барих” ажлын тендериийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 3 удаа зарлаж, эхний 2 удаад ямар нэг компани оролцоогүй. Харин 3 дахь удаад нэг компани оролцсон боловч сонгон шалгаруулалтанд тэнцээгүй. Сүүлийн сонгон шалгаруулалтыг 11 дугээр сарын 29-ний өдөр зарлаж, 12 дугаар сарын 4-нд нээлт хийж дүгнэн, Суврага Өндөр компани шалгарч, мэдэгдэл хулээн авсан. БНАУ-д үйлдвэрлэсэн “NATRO” холимог үрийг БНХАУ-аас 2016 онд оруулж ирсэн 2 төрөл б зүйл ургамлын холимог уртэй харьцуулсан үрийн ерөнхий шинжилгээ, стрессийн шинжилгээг ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Хөрс	82%

агрохимийн лабораатори болон Био-Экологийн хүрээлэнгийн Хөрс ургамлын лабараторт тус тус хийлгэсэн. Шинжилгээний үр дүнд үрийн чанар 50%-иас дээш гарсан. Үүнтэй уялдуулж ногоон тэжээлд зориулж үетэн болон буурцагтан ургамлаас бурдсан 2 төрлийн 8 зүйлийн 21 сортын "NATRO" олон наст ургамлын үрийн холимгоор туршилтын талбайн өнгөрсөн жил хадалт хийсэн 6 га талбайд үрийн нормыг 1 га-д 25 кг-аар тооцож тариалалтын ажлыг 5 дугаар сард гүйцэтгэсэн.

Фермийн ойролцоо малчин өрхүүд болон өөрсдийн үнээ, малаас гарсан өтөг буучыг ашиглан 100 тонн органик бордоо бэлдсэн. Туришилтын 150 га талбайд хийлгэсэн хөрсний агрохимийн шинжилгээний дүнг харгалзан бордох талбайг сонгож, 5 га газарт бууч цацаж, 10 га талбайг компост бордоогоор бордсон. Мөн тариалалт хийгдээгүй 12 га газрыг намар бууцаар бордсон.

2018 онд тарьсан "NATRO" олон наст ургамлын холимог үрийг манай оронд нутагшсан бусад тэжээлийн олон наст ургамлын холимог уртэй харьцуулсан туршилтын ажлыг үргэлжлүүлж, ажиглалт судалгаа хийхэд тариалалт хийх хугацаанд хур тундас бага орсноос хамаарч илт ялгарсан үр дун гараагүй. Тайланийн хугацаанд нийт тариалалт хийсэн 80 га талбайгаас сонготт хийж, өвс ургамлын гарц илүү 15 орчим га талбайгаас өвс хадаж, 500 кг жинтэй 11 ширхэг рупон боодол /нийт 5,5 тонн/ вакумжуулсан ногоон тэжээл хураан авч, 12 дугаар сараас эхлэн саагийн 3 үнээ сонтон, энэхүү ногоон тэжээлээр тэжээж, сүүний гарц хэрхэн нэмэгдэж байгаа туршилтыг эхтуулсэн.

2020 онд "Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж хадгалах байр барих" тендert ялсан "Суврага өндөр" компанийн мэргэжилтнүүдтэй хамтран талбайн хэмжилт хийх, хөрсний дээж авах болон ажлын зураг боловсруулан батлуулахад шаардлагатай баримт бичгийг гарган өгч хамтран ажилласан. Төлөвлөгөөний дагуу 5 дугаар сард барилгын суурин ажлыг эхтуулж, барилга угсралтын ажлыг шат дараалан амжилттай гүйцэтгэн, 8 дугаар сарын 20 -ны өдөр барилгын ажлыг бурэн дуусгаж, Гүйцэтгэч байгууллагын зүгээс Нийслэлийн

Хөрөнгө оруулалтын газарт Улсын комисс ажиллуулан, уг объектийг хүлээн авах талаар хүсэлт тавьсан. Өнөөдрийн байдлаар Улсын комисс хүлээн авах ажил хулээгдэж байна. Түршилтын талбайгаас 11 га-г азот, фосфор, калийн нийлмэл эрдэс бордоогоор бордсон. Мөн 5 га талбайг өнгөрсөн жилийн бэлтгэсэн компост бордоогоор, 9 га талбайг бууцаар бордох ажлыг хийж гүйцэтгэв. БНАУ-ын 2 төрөл, 8 зүйл, 21 сортын тэжээлийн олон наст ургамлын холимог урээр 2020 оны 05 дугаар сарын 1 дүгээр арав хоногт багтаан 5 га талбайд, БНАУ-аас гаралтай 6 зүйл тэжээлийн олон наст ургамлын холимог урээр 3 га талбайд үрлэгээ хийсэн. Мөн зуны бороо угтуулж буугаар сарын 2-р арав хоногоос эхэлж улдэгдэл хятад урээр нийт 24 га-д, БНАУ-аас ирсэн 7 зүйл ургамлын хольцоос бурдсан урийг турших зорилгоор 0.5 га-д тус тус тариалалт хийсэн. Дээрх холимог урнуудэд өнгөрсөн жил хийгээсн лабораторийн шинжилгээний хариутай уялдуулан Урийн нормыг 2 дахин ихээсгэж 1 га-д 30 кг-аар тооцсон. Монгол Улсын Их Сургууль, Ургамал хамгаалын хүрээлэн, Төв Азиин хөрс судалын холбоо зэрэг байгууллагын эрдэмтэн, судлаачидтай хамтран хөрс сайжруулах, организк бордоо бэлтгэх, нэг болон олон наст таримал тариалж тэжээлийн чанарыг үнэлэх, турших зорилгоор түршилтийн ажил хийж эхэлсэн. Дараа жил үргэлжлүүлэн хийгдэнэ.	Хавар эрт тарьсан талбайнудаас болон, өнгөрсөн жил тариалалт хийсэн талбайгаас намар ургац хураалт хийж 20 тоодол 10000 кг орчим вакумжуулсан ногоон тэжээл хураан авсан. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ногоон тэжээл хураан авахад 1 га-ын дундаж ургац 450-550 кг-ыг авч байсан бол 2020 оны байдлаар хөрсөнд урьдчилан боловсруулалт хийж, Натро урээр тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үтээн ургамлыг ургуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлж 1 га-ын дундаж ургацыг 1000 кг, бусад талбайн ургацыг 600 кг болгож сайжруулсан. Нийслэлийн Захирагчийн ажлын алба, НХХААГ, Төв Азиин хөрс судалын холбоо, “Өнгө нэм” ТББ, зарим нэр бүхий хоол, хүнс үйлдвэрлэгч	85%

		<p><b>Үр дүн, Үр нөлөө:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Саалийн үнээний загвар ферм барих 2016 онд зарлагдсан нээлттэй тендert шалгарсан “Сайн констракшн” 90 үнээний загвар ферм, сургалтын төвийн барилга, машин механизмын гараж, эвс хадлан хадгалах сарай зэрэг барилга байгууламжууд барьж, хулээлгэн өгсөн.</li> <li>- Нийслэлийн засаг даргын 2017 оны А-873 тоот захирамжийн дагуу хотын мал аж ахуй эрхлэхийг хориглосон бусээс гаргасан малнаас 30 туталтай үнээг сонгон авч, фермд байрлуулан туршилтын ажлыг явуулж байна.</li> <li>- Туршигтын журмаар 2020 онд шинэ төрлийн ногтоон тэжээлээр бордсон сүүний чиглэлийн үнээний сүүний гарц энгийн евсөн тэжээлээр бордсон үнээнээс дунджаар 54 хувиар нэмээдсэн.</li> </ul> <p>2016 оны гүйцэтгэлийг 2020 онтой харьцуулсаад 10 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт ажлуудын Гүйцэтгэлийн дундаж хувь 80,5% байна.</p>		
2.	1.3.5	<p>Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.</p> <p>Биелэлт:</p> <p>2017 онд Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 110 морьны хүчтэй Нью Холланд маркийн тракторын хөдөлгүүрийн зугшруулэлт, тохиргооны ажлыг гүйцэтгэж, 300 мот.цаг явсны дараа Энсада компанийн мэргэжилтийн техникийн үйлчилгээ хийсэн. Мөн бууч цацагч, бордоо цацагч болон урлэгч машиныг ажиллуулан, туршилт тохируултын ажлыг дээрхи компанийн мэргэжилтийн хамтран 6 дугаар сард амжилттай зохион байгуулсан.</p> <p>Австрии улсын 2 төрлийн, 8 зуigliйн 21 сортын тэжээлийн олон наст ургамлын холимог Урээр батлагдсан технологийн картын дагуу тариалалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байсан болоч хавар, зуны улираад хуурайшилт ихтэй, бороо орохгүй гандуу байсныг харгалзан, Австри</p>	БМТН-ОНӨТҮГ	Ж.БАТБАЯСГАЛАН

улсын мэргэжилтэн тариалалтын ажлыг бүтэн жилээр хойшшуулах шаардлагатай болсон. Олон наст үрийн холимог худалдан авах хөрөнгийн асуудлыг ХХАДАЯ-нд хандаж шийдвэрлэсэн бөгөөд 2018 онд Австралийн нийтийн төлөвлөсөн.	Бүхтраберын зөвлөсний дагуу тариалалт хийсэн. Үрийн нормыг 1 га-д 32 кг-аар тооцож, хөндөхгүйгээр өнөөн хэсгийн сийрүүлэлттүйг агротехнологийн дагуу хийж зориулаалтын үрлэгчээр хавж үрлэсэн. Бороо ороогүй, хэт халуун байснаас хамаарч тариалсан талбайн цухуйгт муу байсан. Харин 8-р сард бороо үргэлжлэн орсон, мөн талбайд цацсан комплекс эрдэс бордооны үйлчлэлээс хамаарч БНХАУ-ын олон наст ургамлын холимог үрээр тариалалт хийгдсэн 20 га талбайн зарим зүйлийн үтээн ургамлуудын цуухийлт сайжирч ургасан. Байнгын усалгаа хийсэн нөхцөлд БНХАУ-ын болон БНХАУ-ын олон настын холимог үр сайн үргэж байгаа нь туршилтын явцад ажиглагдсан. Үтээн ургамлын өндөр 20-40 см, буурцагт ургамлын өндөр 20 см болж, буталж салаалсан. БНХАУ-ын 2 төрөл б зүйл, БНХАУ-ын 2 төрөл, 8 зүйл, 21 сортын бэлчээрийн олон наст үрийн холимог үрээр харьцуулсан туршилтыг 96 м <sup>2</sup> талбайд явуулсан. Туршилтын үр дүнгээс хараад БНХАУ-ын болон БНХАУ-ын олон наст таримлын холимог үрийн усалгаатай, эрдэс бордоогоор бордсон хувилбар бусдаас ипүү сайн үргэж байсан, усалгаатай, буучан бордоогоор бордоон, байгалийн ургамал нь дийлж ургасан хувилбарууд дээр үргалт нь маш тааруу байсан.	2018 онд Натро олон наст ургамлын холимог үрийг тариалах арга технологийн дагуу Guettler үрлэгчийг ашиглан 05 дугаар сард 40 га талбайд, 6 дугаар сард 40 га талбайд тариалалтын ажлыг гүйцэтгэсэн. Тариалалт хийсэн нийт талбайн хэмжэээр авч үзвэл ургалтын эрчим олон наст ургамлын үрийн тариалалтын эхний жил учир харьцаангуй бага гарсан. Нийт тариалалт хийсэн 80 га талбайн 70 %-д олон наст таримлын ургалт 8-15 см, 20 %-д 20-30 см орчим өндөртэй

	<p>байлаа. Хоёр зүйлийн буурцагтан болох Мөлхөө хошонгорт Царгасаас царгас нь ургасан, 6-н зүйлийн үетэнээс Dactylioglossum, Loliumpereae буюу Олон наст риэгэрэс, Нууын дурваалиг, Улаан ботууль зэрэг үетэн ургасан. Нууын биелгэг өвсний ургалт мүү харин Хуурамч овьёös нэртэй үетэн ургамал огт ургаагүй нь ажиглагдсан. Тариалалт хийсэн талбайгаас туршилтийн журмааар 800 кг-ийн жинтэй 2 бодол өвсийг преслэн, вакумжуулан боож, ногоон тэжээл бэлтгэх ажлыг амжилттай явуулсан.</p> <p><b>2019 онд</b> Фермийн ойролцоо Магчин өрхүүд болон өөрдийн малаас гарсан өтөг буучыг ашиглан 100 тонн органик бордоо цуглуулж бэлдсэн. Туршилтын 150 га талбайд хийлгэсэн хөрсний агрохимиин шинжилгээний дунг харгалзан бордох талбайг сонгож, 5 га газарт бууч цацаж, 10 га талбайг компост бордоогоор бордсон. Мөн тариалалт хийгдээгүй 12 га газрыг намар бууцаар бордсон. Нийт тариалалт хийсэн 80 га талбайгаас сонголт хийж, эвс ургамлын гарцуултуу 15 орчим га талбайгаас хадаж, 500 кг жинтэй 11 ширхэг рулон боодол /нийт 5,5 тонн/ вакумжуулсан ногоон тэжээл хураан авсан.</p> <p><b>2020 онд</b> БНАУ-ын 2 төрөл, 8 зүйл, 21 сортын тэжээлийн олон наст ургамлын холимог үрээр 5 дугаар сард 5 га талбайд, БНАУ-аас гаралтай 6 зүйл тэжээлийн олон наст ургамлын холимог үрээр 3 га талбайд үрлэгээ хийсэн. Мөн зуны бороо угтуулж 6 дугаар сард Хятад Үрээр нийт 24 га-д, БНАУ-аас ирсэн 7 зүйл ургамлын хольцоос бурдсэн үрийг турших зорилгоор 0.5 га-д тус тус тариалалт хийсэн. Дээрх холимог үрнүүдэд өнгөрсөн жил хийлгээний лабораторийн шинжилгээний хариутай уялдуулан үрийн нормыг 2 дахин ихэсгэж 1 га-д 30 кг-аар тооцсон.</p> <p>Монгол Улсын Их Сургууль, Ургамал хамгааллын хурээлэн, Төв Азийн хөрс судалалын холбоо зэрэг байгууллагын эрдэмтэн, судлаачидтай хамтран хөрс сайжруулах, организатордоо бэлтгэх, нэг болон олон наст таримал тарилж тэжээлийн чанарыг үнэлэх, турших зорилгоор туршилтын ажил хийж эхэлсэн. Дараа жил Үргэлжлүүлэн хийдэнэ.</p>	80%	

		<p>Хавар эрт тарьсан талбайнуудаас болон, өнгөрсөн жил тариалалт хийсэн талбайгаас намар ургац хураалт хийж 20 бодол 10000 кг орчим вакумжуулсан ногоон тэжээл хураан авсан. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ногоон тэжээл хураан авахад, 1 га-ын дундаж ургац 450-550 кг-ыг авч байсан бол 2020 оны байдлаар хөрсөнд урьдчилсан боловсруулалт хийж, Натро Урзэр тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг угтуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлж 1 га-ын дундаж ургацыг 1000 кг, бусад талбайн ургацыг 600 кг болгож сайжруулсан.</p>	
		<p><b>Үр дүн, Үр нөхөө:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Туршилтын 150 га талбайн 1 га-гийн дундаж ургац 2016 оны байдлаар ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүнээс хамаарч 270-аас 900 кг байсан бол 2020 оны байдлаар хөрсөнд урьдчилан боловсруулалт хийж, малын бууч болон органик бордоогоор бордож, Натро Урзэр тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг угтуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлж 1 га-ын дундаж ургацыг 1000 кг болгож нэмэгдүүлсэн нь 2016 онтой харьцууллахад 110 гаруй хувийн өсөлттэй байна.</li> <li>- Бэлчээрийн талбайг хагалж хөндөлгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулажгүйгээр тариалдаг Австрии улсын шинэ технологийг нэвтрүүлж, тус улсад үйлдвэрлэсэн 2 төрлийн, 8 зүйлийн 21 сортын олон наст ургамлын үрийн холимог “Натро Үр”-ийг тариалж, 2018 онд 800 кг-тай 2 рулон буюу 1600 кг шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэн нийтүүлж байсан бол 2019 онд 5500 кг, 2020 онд 10000 кг тус бэлтгэн өмнөх онтой харьцуулахад 180 гаруй хувиар нэмэгдүүлсэн.</li> <li>- Газар тариалангийн салбарт нэвтэрч буй бэлчээрийн талбайг хагалахгүйгээр тариалдаг Австрии улсын дээр дурьдсан шинэ техник, технологийг иж бүрэн нийтүүлж, туршилт, тохируулгын амжилттай гүйцэтгэсэндийн үр дунд Монгол улсын ногоон хөгжлийн бодлогод нийцсэн бэлчээрийн талбагдлыг бууруулах, цэлжилтийг зогсоох боломж бурдсэн.</li> </ul> <p><b>2016 оны гүйцэтгэлийг 2020 онтой харьцуулахад 7 хувийн өсөлттэй гарсан бөгөөд нийт ажлуудын Гүйцэтгэлийн дундаж хувь 81,5 хувьтай байна.</b></p>	
3.	1.6.5	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах Үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд олон нийтийн оролцоо, хянаптыг нэмэгдүүлнэ.</p>	

2016 онд	Нийт 1,055,364,496 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэнээс НХХААГ-аас зарлагдсан тендерийн дагуу "Энсада трактор" ХХК 917,600,000 төгрөгийн Хадлан, тэжээл бэлтгэх зориулалттай техник тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн. Мөн хашаа хайсны 137,764,496.40 төгрөгийн бүтээн байгуулалт хийгдсэн байна.	Байгууллагын дансанд буртгэлгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлаар хийгдсэн фермийн барилга байгууламж 890 сая болон 56 сая төгрөгийн 2 ш худагийг Нийспэлийн Өмч ашиглалт, удирдлагын газрын албан тоотын дагуу хүлээн авах ажлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хандсан байгаа. Мөн фермийн 1 га газрын гэрээг хийж мэргэжлийн үнэлгээний газраар үнэлүүлэн дансанд буртгэлжүүлэх ажлууд байна.	80%	
2018 онд	Нийспэлийн худалдан авах ажиллагааны газраас зарлагдсан тендергт "Глобал бизнес" ХХК шалгарч 226,202,519 төгрөгийн 9 нэр төрлийн бага оврын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, 1 авто машин нийлүүлсэн.	2018 онд Нийспэлийн худалдан авах ажиллагааны газраас зарлагдсан тендергт "Глобал бизнес" ХХК шалгарч 226,202,519 төгрөгийн 9 нэр төрлийн бага оврын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, 1 авто машин нийлүүлсэн.	80%	
2019 онд	Нийспэлийн худалдан авах ажиллагааны газраас зарлагдсан 150,500,000 төгрөгийн төсөвтэй техник тоног төхөөрөмжийн агуулах барих тендергт "Суврага ондөр" ХХК шалгарч ажлыг хийж гүйцэтгэсэн.	Дээрхи ажил нь 2020 онд Ургэлжлэн хийгдэж дууссан. Улсын комисс барилгыг хулээж аваагүй байгаа болно.	90%	
		<b>Үр дүн, үр нөлөө:</b>		
		- Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөдөө, аж ахуйн техник, тоног төхөөрөмжүүд иж бурэн туршилт, тохируулгын ажил амжилттай хийдсэний ур дунд бэлчээрийн талбайг хагалзахгүйгээр 21 төрлийн урийн холимог бүхий Натро тариалж, шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэн, саалийн үнээний сууний гарцыг нэмэгдүүлсэн. - Хөдөө аж ахуйн зориулалт бүхий бага оврын анжис, хүнд дискт, роторт сийрүүлэгч, төмс үрлэгч, төмс хураагч, усалгааны систем, нарийн ногооны үргэлж, хор цацагч төмсний кон болон 5 тоннын даацтай өргөч кран зэрэг 10 төрлийн тоног төхөөрөмжүүдийг		

		нийгүүлэгдсэнийй Үр дунд газар тариалангийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжийн захиалгаар чанарын өндөр тувшинд гүйцэтгэх боломж бурдэж, 2020 онд 5 иргэн, 2 аж ахуйн нэгжийн захиаллын дагуу талбайн боловсруулалт хийх, хадлан тэжээл болон тэмс хураах ажлуудыг гүйцэтгэсэн.	
4.	5.2.4	2016-2020 хооронд хийж гүйцэтгэсэн ажлын дундаж 83,3 хувьтай байна.  Төрийн Үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай баримт материалиг тоон хэлбэрт шилжүүлэн, салбар бүрийн цахим мэдээллийн нэгдсэн сан/ цахим архив/-г үүсгэнэ.	
		2016 онд Даргын А тушаал 17, Б тушаал 17 гарсан E.Doc програмд цахим архив үүсгэсэн. 2017 онд Даргын А тушаал 30, Б тушаал 55 гарсан E.Doc програмд цахим архив үүсгэн хадгалсан. 2018 онд Даргын А тушаал 22, Б тушаал 34 гарсан E.Doc програмд цахим архив үүсгэн хадгалсан байна. 2019 онд Даргын А тушаал 28, Б тушаал 28 гарсан E.Doc програмд цахим архив үүсгэн хадгалсан. 2020 онд Даргын А тушаал 17, Б тушаал 43 гарсан E.Doc програмд цахим архив үүсгэн хадгалахад бэлэн болсон.	85%
		Үр дун, Үр нэлөө: 2016-2020 оны даргын А, Б тушаалыг цахим хэлбэрт шилжүүлсэнээр E.Doc програмаас шууд харах боломжтой болсон. Тоон Үзүүлэлтээр 85%-тай хэрэгжсэн.	

**"БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ" ОНӨТГҮГ**  
**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГДАНЫ**  
**ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**  
**ҮНДСЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ 4 АРГА ХЭМЖЭЭ**

2020 оны жилийн эцсийн байдлаар

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хөтөлбөгийн ажиллагааны хөтөлбөгийн хөтөлбөгийн төслийн төслийн нийт 4 арга хэмжээнд үндсэн хэрэгжүүлэгчээр туссан нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ҮР ДҮНТЭЙ (100%)	4
ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХУРСЭН (70 %)	-
ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ (40 %)	-
ҮР ДҮНГҮЙ (0-30 %)	-
ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙ	-
<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>82,57 %</b>

**ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ БОЛНО.**

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөгийн хөтөлбөгийн төслийн төслийн нийт 4 арга хэмжээнд үндсэн хэрэгжүүлэгчээр туссан нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
ҮР ДҮНТЭЙ (100 %)	-
ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХУРСЭН (70 %)	-
ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ (40 %)	-
ҮР ДҮНГҮЙ (0-30 %)	-
ҮНЭЛЭХ БОЛОМЖҮЙ	-
<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>82,57 %</b>

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 4 арга хэмжээнд 82,57 %-ийн биелэлттэй байна.  
 Улаанбаатар хот

БОЛОВСРУУЛСАН: **БЭЛЧЭЭРГИЙН ЧУМЧИГ** Г.ПУРЭВСҮРЭН  
 ТӨСЛИЙН МЕНЕЖЕР НЭЧИЧИЙН ЧУМЧИГ  
 ХЯНАСАН:  
 ДАРГА  
**Г.ГАЛДӨЛ**  
 6046631-11161178863

2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ИНСТИТУЧИГЫН БИЕЛЭЛТ НИЙН СПЛЭГИЙН ЗАСАГ, НИЙМЛИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ИНСТИТУЧИГЫН БИЕЛЭЛТ

2020.12.25

д/д	Үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Нийслэлийн Эдийн засаг, нийтмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгур үзүүлэлт, хүрэх түвшин	Зарцуулсан хөрөнгө эх Уусвэр /сая.төг/	
1	1.3.5	Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, эрхийн тариаланг нэмэгдүүлэн хөрс цаг уурын онцлогт тохиирсон таримлыг Тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.	1-36. Бэлчээрийн талбайд олон настын үрийн холимгоор тариалалт хийж, хөрсний чанарыг сайжруулна.	БМТН-ОНӨТҮГ 1. 1 га-аас авах ногоон тэжээлийн ургацын өсөлт, дахин их 2. Машин, тоног төхөөрөмж хадгалах байр тоо	Хүрэх түвшин 1 2	Зарцуулсан хөрөнгө эх Уусвэр /сая.төг/ - 150.5
<b>НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРҮҮДНЭЙХН ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭП/ПУСГАЙЛАН ЗААСАН ЗААЛТ БАЙХГҮЙ 2019 ОНД</b>						
<b>НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭП/ПУСГАЙЛАН ЗААСАН АЖЛЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХИЙЖ БАЙНА!</b>						
тусгагдсан ажлыг үргэлжлүүлэн хийж байна! /						
<b>Шалгур үзүүлэлт 1.</b> Энэ жил БНАУ-ын 2 төрөл, 8 зуйл, 21 сортын тэжээлийн олон наст ургамлын холимог урээр 05 дугаар сарын 1 дугээр арав хоногт багтаан 5 га талбайд, БНХАУ-ас гаралтай б зуиль тэжээлийн олон наст ургамлын холимог урээр 3 га талбайд. Үрлэгээ хийсэн. Зуны бороо угтуулж 6 дугаар сарын 2-р арав хоногоос эхэлж, Хятад үрээр нийт 24 га-д, БНАУ-аас ирсэн 7 зуйл ургамлын хольцоос бурдсан урийг түрших зорилгоор 0.5 га-д тус тус тариалалт хийсэн. Дээрх холимог урнуудад өнгөрсөн жил хийлгэсэн лабораторийн шинжилгээний хариу үндэслэн, үрийн нормыг 2 дахин ихэсгэж 1 га-д 30 кг-аар тооцож, үрлэгээний ажлыг явуулав. Мөн түршилтын талбайд сонголт хийж, нийт 11 га газрыг азот, фосфор, калийн /NPK/ нийтмэл эрдэс бордоогоор 5 га талбайг өнгөрөөн жил бэлтгэсэн компост бордоогоор, 9 га талбайг малын өтөг бууцаар бордох ажлыг хийж гүйцэтгэв. Нийслэлийн Захиргачийн ажлын алба, НХХААГ, Төв Азиин хөрс судалын холбоо, “Өнгө нэм” ТББ, зарим нэр бүхий хоол, хүнс үйлдвэрлэгч байгууллагуудтай хамтран хүнсний био хог						

<p>хаягдал малын өтөг буучыг холбж 200 тн комплост бордоо хийхээр төлөвлөсөөс 80 тн-ыг цуплуулж бордоо болгохоор ажиллаж байна. 2020 оны 9-р сарын 14-ний байдлаар Натро болон Хятад Урээр тариалалт хийсэн 5 га, өнгөрсөн жил тариалалт хийсэн 8 га-аас 450 кг-тай 20 боодол ногоон тэжээл хураан авваад байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ногоон тэжээл хураан авваад 1 га-ын дундаж ургац 450-550 кг-ыг авч байсан бол 2020 оны байдлаар Натро Урээр бордоож тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг угтуулж төрөл зүйлийг Нэмэгдүүлж 1 га-ын дундаж ургацыг 1000 кг, бусад талбайн ургацыг 600 кг болгож сайжруулсан.</p>	<p><b>Шалтуур үзүүлэлт 2.</b> “Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж хадгалах байр барих” төндөрт ялсан “Суврага ондөр” компанийн мэргэжилтнуудтай хамтран талбайн хэмжилт хийх, хөрсний дээж авах болон ажлын зураг боловсруулан баттууллахад шаардлагатай баримт бичгийг гарган өгч хамтран ажилласан. Төлөвлөгөөний дагуу 5 дугаар сард барилгын суурин ажлыг эхлүүлж, барилга угсралтын ажлыг шат дараалан амжилттай гүйцэтгэн, 8 дугаар сарын 20-ны өдөр барилгын ажлыг бүрэн дуусгаж, Гүйцэтгэч байгууллагын зүгээс Нийспэллийн Хөрөнгө оруулалтын газарт улсын комисс ажиллуулан, уг обьектийг хүлээн авах талаар хүсэлт тавьсан. Өнөөдрийн байдлаар Улсын комисс хүлээн авах ажил хүлээгдэж байна.</p>	<p>Энэхүү ажлууд амжилттай хийгдсэнээр нийспэл орчмын бэлчээрийн талхагдал буурч, хөрсний үржил шим нэмэгдэж, бэлчээрийн талбайн ургамлын төрөл зүйл нэмэгдэж, ашиглалт сайжирна. Шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэн нийлүүлсний үр дунд саалийн хугацаанд үнээний сүүний гарц 1.5-2 дахин нэмэгдэх боломж бурдэнэ.</p>
	<p>Үр дүн, үр нөлөө:</p> <p>Ургамлын төрөл зүйл нэмэгдэж, ашиглалт сайжирна.</p>	<p>87,5%</p>

"БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ" ОНӨТГҮ  
НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ  
ҮНДСЭН ХЭРЭГЖКҮЛЭХ 2 АРГА ХЭМЖЭЭ

2020 оны жилийн эцсийн байдлаар

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭПД ҮНДСЭН ХЭРЭГЖКҮЛЭГЧЭЭР ТУССАН НИЙТ 2 АРГА ХЭМЖЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖКҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.	
ҮР ДҮНГТЭЙ (100%)	95%
ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХУРСЭН (70 %)	80%
ЭРЧИМЖКҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ (40 %)	-
ҮР ДҮНГҮЙ (0-30 %)	-
ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ	-
<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>87,5%</b>

**ХАМТРАН ХЭРЭГЖКҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ БОЛНО.**

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭПД ХАМТГАН ХЭРЭГЖКҮЛЭГЧЭЭР ТУССАН НИЙТ ..... АРГА ХЭМЖЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖКҮЛЭН АЖИЛЛАЖ ..... %-ИЙН ГҮЙЦЭГЭЛТЭЙ АЖИЛЛАЖ БАЙНА.	
ҮР ДҮНГТЭЙ (100%)	-
ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХУРСЭН (70 %)	-
ЭРЧИМЖКҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ (40 %)	-
ҮР ДҮНГҮЙ (0-30 %)	-
ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ	-
<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>87,5%</b>

Нийслэлийн Эдийн засаг, нийтмийг 2020 онд хөгжүлэх үндсэн чиглэлд хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 2 арга хэмжээний биелэлт 87, 5 %-ийн биелэлттэй байна.



БОЛОВСРУУЛСАН:   
Г.ПУРЭВСҮРЭН  
УЛААНБААТАР ХОТ  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР  
ВЭЛИНЗЭРИЙН  
МЕНЕЖМЕНТ  
ТЕСЛИЙН НЭГЖ  
ХЯНАСАН  
ДАРГА  
Г.ГАЛДӨЛ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ОРСОН “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-Т ХАМААРАЛТАЙ ЗААЛТУУДЫН БИЕЛЭЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2020.12.28

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт манай байгууллагын зүгээс дараах 2 заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, амжилттай биелүүлсэн болно. Үүнд:

- 1.3.3. “Мал аж ахуйг эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, сүү, махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар нийслэлийн хүн амын сүү, махны хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангана” заалтын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
  - Саалийн үнээний загвар ферм барих 2016 онд зарлагдсан нээлттэй тендерт шалгарсан “Сайн констракшн” 90 үнээний загвар ферм, сургалтын төвийн барилга, машин механизмын гараж, ёвс хадлан хадгалах сарай зэрэг барилга байгууламжууд барьж дуусган, хүлээлгэн өгсэн.
  - Нийслэлийн засаг даргын 2017 оны А-873 тоот захирамжийн дагуу хотын мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс гаргасан малнаас 30 тугалтай үнээг сонгон авч, уг фермд байрлуулан туршилтын ажлыг явуулах боломж бүрдсэн.




Зураг № 1,2. 90 үнээний загвар фермийн үйл ажиллагаатай танилцаж байгаа нь

- Саалийн үнээнүүдээс харилцан адилгүй сүүний гарцтай 3-4 үнээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор сонгон авч 2019 оны өвөл вакумжуулан боож бэлтгэсэн ногоон тэжээлээр тэжээж, сүүний гарцны харьцуулсан судалгааг хийсэн. Судалгааны үр дүн нь 2019 онд 2 үнээний сүүний дундаж гарц 47,5%, 2020 онд 3 үнээний сүүний дундаж гарц 54,3% болон нэмэгдсэн байна.

**Шинэ төрлийн ногоон тэжээлээр тэжээсний дараа саалийн үнээний сүүний гарц нэмэгдсэн байдал /2020.01.01-2020.01.31/**

№	Хяналтын үзүүлэлт	Эхний саамны хэмжээ, гр	Эцсийн саамны хэмжээ, гр	Саамны нэмэгдсэн хэмжээ, гр	Нэмэгдсэн хувь
1.	Цагаан үнээ	1420	2300	880	61%
2.	Хар халзан үнээ /18571/	1580	2230	650	41%
3.	Бор алаг үнээ /018579/	1430	2310	880	61%



*График №1.*

**1.3.5. Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ. Энэ заалтын хүрээнд дараахь ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:**

- Туршилтын 150 га талбайн 1 га-гийн дундаж ургац 2016 оны байдлаар ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүнээс хамаарч 270-аас 900 кг байсан бол 2020 оны байдлаар хөрсөнд урьдчилан боловсруулалт хийж, малын бууц болон органик бордоогоор бордож, Натро үрээр тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг ургуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлж 1 га-ын дундаж ургацыг 1000 кг болгож нэмэгдүүлсэн нь 2016 онтой харьцуулахад 110 гаруй хувийн өсөлттэй байна.
- Бэлчээрийн талбайг хагалж хөндөлгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр тариалдаг Австри улсын шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, тус улсад үйлдвэрлэсэн олон наст ургамлын үрийн холимог “Натро үр”-ийг тариалж, 2018 онд 800 кг-тай 2 рулон буюу 1600 кг шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэн нийлүүлж байсан бол 2019 онд 5500 кг, 2020 онд 10000 кг тус тус бэлтгэн өмнөх онтой харьцуулахад тэжээлийн хэмжээг 180 гаруй хувиар нэмэгдүүлсэн.
- Бэлчээрийн талбайг хагалахгүйгээр тариалах Австри улсын газар тариалангийн салбарт нэвтэрч буй дээр дурьдсан орчин үеийн шинэ техник, технологийг иж бүрэн нийлүүлж, туршилт, тохируулгын амжилттай гүйцэтгэсэний үр дүнд бэлчээрийн талхагдлыг бууруулах, цөлжилтийг зогсоох боломж бүрдсэн.



*Зураг №3,4. Герман улсад үйлдвэрлэсэн Гуттлер үрлэгчийг ашиглан тариалалтын ажил хийж байгаа байдал /2016 он/*





Зураг №5. Тариалалт хийгдээгүй талбай




Зураг №6. Тариалалт хийгдсэн талбай

/2017 он/



Зураг №7,8,9. Нийлмэл эрдэс бордоо болон органик бордоогоор талбайг бордсон байдал

/2020 он/



Зураг №10,11. Органик болон эрдэс бордоогоор бордож, тариалалт хийсэн талбай

/2020 он/



**Зураг №:12,13,14,15.** Ногоон тэжээлийн ургац болон хадлан авч, шинэ төрлийн вакумжуулсан ногоон тэжээл бэлтгэсэн байдал /2020 он/

2018 онд туршилтын журмаар 15 га талбайгаас 9-р сарын эхээр түүвэрлэсэн хадалт хийж 800 кг-тай 2 боодол ногоон тэжээл, 400 кг-аар преселж боосон 3200 кг өвсөн тэжээл хураан авсан. Ургац хураалтаас өмнө 5-н цэгээс 1 м<sup>2</sup> талбайгаас 3-н давталттай өвсний дээж авч өрөнхий шинжилгээ хийлгэсэн. Вакумжуулсан ногоон тэжээл бэлтгэсэн хэсгийн уургийн агууламж нь 2%-иар илүү байсан. Тайлбарыг График № 2- т харуулав.




**График №2.**




**График №3**

- 2019 онд 15 га газраас 8,9 дүгээр сард ургалтын хэмжээнээс хамааруулан түүвэрлэн хадалт хийж, 11 рулон буюу 5500 кг ногоон тэжээл хураан авсан бөгөөд 2018, 2019 оны 1 га талбайн дундаж ургац 500-550 кг байсан.



**Зураг №5. Вакумжуулсан ногоон тэжээл**

Эрдэс бордоогоор бордсон хөрсний ялзмагийн агууламж 2.76%-аас 3.99% болж 1.23 %-аар, шим тэжээлийн элементүүд 100 гр хөрсөнд нитрат азот /NO3/ 1.65 мг-аас 3.19 мг болж 1.54 мг-аар, фосфор /P2O5/ 1.6 мг-аас 2 мг болж 0.4 мг-аар, кали /K2O/ 34 мг-аас 54 мг болж 20 мг-аар тус тус нэмэгдсэн. График №3 –д харуулав.



**График № 4 . Хөрсний шинжилгээний дүн**

Бэлчээрийн аж ахуйд зориулсан New Holland маркийн 2 трактор, бордоо цацагч, холигч ба шүршигчтэй шивх цацагч, үрлэгч Guettler, хадуур, вакумжуулан боох төхөөрөмж, бууц цацагч төхөөрөмж, өвс хадлан баалдах, сэврээх төхөөрөмж зэрэг 8 төрлийн тоног төхөөрөмжүүдийг Энсада компани нийлүүлж, 2017 онд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 100 га газарт байгалийн хадлан авч, хадуур, тармуур, сэврээгч болон пресслэгч төхөөрөмжүүдийг хадлангийн талбай дээр амжилттай туршиж, хүлээн авсан



#### *Зураг № 8,9 Техник, тоног төхөөрөмжийн туршилтын ажил*

Мөн 2018 оны 5 дугаар сард “Глобал бизнес линк” компани хөдөө аж ахуйн зориулалт бүхий бага оврын анжис, хүнд диск, роторт сийрүүлэгч, төмс үрлэгч, төмс хураагч, усалгааны систем, нарийн ногоо үрлэгч, хор цацагч, төмсний кон болон 5 тоннын даацтай өргөгч кран зэрэг 10 төрлийн тоног төхөөрөмжүүдийг амжилттай нийлүүлж, иргэд, аж ахуйн нэгжийн захиалгаар хямд үнээр чанарын өндөр түвшинд газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн.



#### **ЦААШИД АНХААРАХ ЗҮЙЛ:**

- Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон Монгол улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгүүдийн Ногоон хөгжлийн хэсгийн заалтад орсон “Хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, газрын доройтлыг бууруулан, цэлжилтөөс сэргийлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын 2021 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд заалт оруулж, хэрэгжүүлэх

**Танилцуулга бэлтгэсэн:**

**Төслийн менежер**

*Г.Пүрэвчурх*

**Г.Пүрэвсүрэн**

**Хянасан:**

**Дарга**

*Дарга*

**Г.Галдэл**

**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ  
ОНӨТҮГ-Н ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 12 дугаар сарын 25

№

Улаанбаатар хот

Хурал 10:00 цагт байгууллагын даргын өрөөнд эхлэв.

Хурлыг удирдсан: Дарга Г.Галдөл

Хуралд оролцсон: Төслийн менежер Г.Пүрэвсүрэн, Нягтлан бодогч Ц.Мөнхдөл, Агрономч Б.Баярцэцэг, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн Х.Гэрэлцэцэг нар оролцов.

**Хэлэлцэх асуудал:**

- Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн тухай
- Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай
- Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Төслийн менежер Г.Пүрэвсүрэн танилцуулав.

Менежер Г.Пүрэвсүрэн: Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт манай байгууллагын зүгээс 1.3.3 болон 1.3.5 гэсэн тодорхой 2 заалтын хүрээнд ажил гүйцэтгэж ирлээ. Эхний заалт бол “Мал аж ахуйг эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, сүү, махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар нийслэлийн хүн амын сүү, махны хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангана” гэсэн том зорилтын хүрээнд хийгдэх ажил байлаа. Энэ ажлын хүрээнд 90 үнээний загвар ферм барьж, ашиглалтанд оруулсан, нийслэлийн хориглосон бүсээс гаргасан иргэдийн малнаас 30 тутгалтай үнээ сонгон авч, уг фермд байрлуулсан, шинэ төрлийн ногоон тэжээлээр саалийн үнээг туршилтын журмаар бордож, тодорхой үр дүнд хүрсэн зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ. Харин 2 дугаар заалт бол “Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ” гэсэн манай “Бэлчээрийн менежментийг сайжруулан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” тухай хөтөлбөртэй шууд холбоотой заалт юм. Бид энэ ажлын хүрээнд ч мөн багагүй ажлуудыг гүйцэтгэсэн. Тайлангийн хугацаанд төслийн хүрээнд нийлүүлэгдэх хөдөө аж ахуйн бүхий л техник, тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, туршилт тохируулгын ажлыг амжилттай явуулж, хүлээн авлаа. Мөн эдгээр техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглан хөрс боловсруулах, тариалах, хураан авах болон вакумжуулан боож, шинэ төрлийн ногоон тэжээл гарган авах ажлыг туршиж, амжилттай гүйцэтгэлээ. Хэдийгээр дээрхи ажлуудыг хэрэгжүүлэх явцад цаг агаарын хүндрэлтэй нөхцөл үүсч, бороо хур орохгүй байх, олон настын үрийн холимог худалдан авах санхүүжилтийн асуудал шийдэгдэхгүй хойшлогдох, барилгын ажлын тендерт

ялсан компани ажлаа дутуу гүйцэтгэх зэрэг байгаль цаг уур, санхүү болон техникийн асуудлууд гарч байсан ч гэсэн үндсэн ажлуудаа гүйцэтгэхийн төлөө манайхан сайн ажилласан гэж үзэж байна.

Харин Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухайд бол 2019 оны төлөвлөгөөт ажлаас шилжиж ирсэн “Хөдөө аж, ахуйн тоног төхөөрөмжийн агуулах барих” ажил 8 дугаар сард бүрэн дуусч, улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байгаа. Тийм учраас 2020 оны үндсэн чиглэлийн биелэлт хангалттай гэж үзэж байна. Ногоон масс хэрхэн нэмэгдүүлсэн талаар Баярцэцэг ярих уу.

Б.Баярцэцэг: Бэлчээрийн талбайд олон настын холимог үрээр тариалалт хийж хөрсний чанарыг сайжруулах арга хэмжээний нэг шалгуур үзүүлэлт нь 1 га-аас авах ногоон тэжээл буюу ургацын хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ гэсэн заалт байсан. Манай туршилтын 150 га талбайн хувьд 1 га-ийн ургац дийлэнхи талайд 450 кг-аас бага байдаг. Үүнийг 2018, 2019 оны ургацаас харж болно. Харин энэ жилийн хувьд эрт 5 дугаар сарын эхээр органик болон эрдэс бордоогоор бордож, Натро үрээр тариалалт хийсэний үр дүнд 1 га-гийн ургацыг 1000 кг хүргэж бараг 2 дахин нэмэгдүүлж чадсан. Мөн буурцагтан ургамал сайн ургахгүй байсаныг цэцэглэж амжаагүй ч ургуулж, ургамлын төрөл зүйлийг нэмж чадсан. Энэ бол бид нарын ажлын бас нэг амжилт гэж бодож байна.

Ц.Мөнхдөл: 2016-2020 оны байдлаар нийт 1,281,567,015 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэнээс хөдөө аж ахуйн том оврын техник тоног төхөөрөмжүүд нийт өртөг 917,600,000 төгрөг, хашаа хайсны нийт өртөг 137,764,496.40 төгрөг, 9 нэр төрлийн бага оврын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, 1 авто машины нийт өртөг нь 226,202,519 төгрөг байсан байна. 2019 онд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарлагдсан 150,500,000 төгрөгийн төсөвтэй техник тоног төхөөрөмжийн агуулах барих тендерт “Суврага өндөр” ХХК шалгарч ажлыг хийж гүйцэтгэсэн. Дээрхи ажил нь 2020 онд үргэлжлэн хийгдэж дууссан. Улсын комисс барилгыг хүлээж аваагүй байгаа болно.

Ер нь жил болгон Урсгал үйл ажиллагааны төсвийн төсөлд болон Нийслэлийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үр, бордооны мөнгө хүссэн боловч батлагдаагүй учраас байгууллагын батлагдсан төсвөөс тодорхой хувийн зардал гаргаж 2019 оны тариалалт хийсэн Натро үр эрдэс бордоог авсан. 2021 оны төсвийн төсөлд мөн тусгасан байгаа.

Цаашид 2021 онд хийгдэж шийдвэрлүүлэх асуудлууд болох байгууллагын дансанд бүртгэлгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлаар хийгдсэн фермийн барилга байгууламж болон 2 ш худагийг Нийслэлийн Өмч ашиглалт, удирдлагын газрын албан тоотын дагуу хүлээн авах ажлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хандсан байгаа. Мөн фермийн 1 га газрын гэрээг хийж мэргэжлийн үнэлгээний газраар үнэлүүлэн дансанд бүртгэлжүүлэх ажлууд байна.

Г.Пүрэвсүрэн: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон Монгол улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгүүдийн Ногоон хөгжлийн хэсгийн заалтад орсон “Хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, газрын доройтлыг бууруулан, цөлжилтөөс сэргийлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын 2021 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд заалт оруулж, хэрэгжүүлэх, шаардлагатай гэж үзэж байна.

Г.Галдөл: Танилцуулга хийсэн хүмүүст баярлалаа, нэмж тодруулах зүйл алга. Та бүхний танилцуулсны дагуу бүх асуудлыг дэмжиж, шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хуралд оролцсон нийт ажилтнууд дээрх гаргасан саналуудыг бүрэн дэмжлээ.

**Хурлын шийдвэр:**

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт заалт бүрээр биелсэн гэж дүгнэх,
2. Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт сайн гэж дүгнэх,
3. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон Монгол улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгүүдийн Ногоон хөгжлийн хэсгийн заалтад орсон “Хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, газрын доройтлыг бууруулан, цөлжилтөөс сэргийлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын 2021 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд заалт оруулж, хэрэгжүүлэх,
4. Байгалийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй, газрын хэвлэлийг хагалахгүйгээр ногоон тэжээл тариалдаг шинэ технологийг амжилттай туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэх зэрэг болно.

Хурал 11:30 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:  
Дарга

Г.ГАЛДӨЛ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН:  
Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн

Х.Гэрэлцэцэг